



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/295

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ГААОНӨГ/2023120111 дугаар бүхий хөргүүртэй 40 тоннын контейнер нийлүүлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Л.Хаш-Эрдэнэ (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Д.Отгонжаргал (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
Т.Галсан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Х.Нордогбат (Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан мэргэжилтэн)

2. Контейнерийг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ